

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Чандмань илч ОНӨХХК-ийн 2019 оны санхүүгийн  
тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/6/СТА-ОНӨААН

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
(Дорноговь аймаг, Сайншанд сум)  
2020 он

Тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа
Утас: 70522734	Цахим хаяг: <a href="mailto:ariunaa.ch@audit.gov.mn">ariunaa.ch@audit.gov.mn</a>
Аудитын менежер:	Ч.Хэрлэнчимэг
Утас: 70523020	Цахим хаяг: <a href="mailto:kherlenchimeg.ch@audit.gov.mn">kherlenchimeg.ch@audit.gov.mn</a>
Аудитор:	Г.Энхтөр
Утас: 99032916	Цахим хаяг: <a href="mailto:ij17.audit@gmail.com">ij17.audit@gmail.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан.....	5
	2.1. Оршил.....	5
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	8
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
	2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	8
	2.9. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .	11
	2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	11
	2.10.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	11
	2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	12
	2.12. Шилэн дансны мэдээлэл .....	12
	2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	12
	2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3	Менежментийн захидал.....	14
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	19

## 1 Аудитын гэрчилгээ



ЧАНДМАНЬ ИЛЧ ОНӨХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Т.АЗБАЯР ТАНАА

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.03.16 № 1-6/331

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чандмань илч ОНӨХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Чандмань илч ОНӨХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлангуудыг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Чандмань илч ОНӨХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Чандмань илч ОНӨХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Чандмань илч ОНӨХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг захирал Т.Азбаярт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чандмань илч ОНӨХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Чандмань илч ОНӨХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Чандмань илч ОНӨХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 27-ноос 2020 оны 3 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захиалгаар Ингүүмэл жаргалант аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Чандмань илч ОНӨХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 149 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС,НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Чандмань илч ОНӨХХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Чандмань илч ОНӨХХК нь хэрэглэгчдийг чанартай дулаанаар хангах, хэрэглэгчдийг үйлдвэрлэлийн болон унд, ахуйн стандартад тохирсон цэвэр усаар тасралтгүй хангаж, экологийн тэнцвэрийг хадгалах шалгуурт нийцэх усыг байгальд нийлүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Компаний үүсгэн байгуулах баримт бичигт зааснаар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Уур үйлдвэрлэл, халуун ус хангамж.
- Хүн ам, үйлдвэрлэлийн хэрэгцээний ус хуримтлуулан ариутгаж, түгээх ажиллагаа.
- Бохир ус, хаягдал цэвэрлэгээ, ариутгалын үйлчилгээ.
- Зочид буудал.
- Дэлгүүр.

- Тоног төхөөрөмж угсралтын болон барилга угсралт, магистраль инженерийн шугам сүлжээ угсрах ажиллагаа.

Компаний үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Чандмань илч ОНӨХХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Усны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон өөрчлөлт гараагүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Чандмань илч ОНӨХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Чандмань илч ОНӨХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Чандмань илч ОНӨХХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Ординат ХХК-ийн "Венница" программ хангамж ашигладаг байна.

Чандмань илч ОНӨХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, тодруулгатай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 37 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож тооцох хувийг 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь өөрийн орлогоор зардлаа санхүүжүүлж байгаатай холбоотой юм.

2019 оны нийт зардал 8,555,424.4 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 17,110.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь үйл ажиллагааны цар хүрээтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Чандмань илч ОНӨХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,617,514.4 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж төлсөн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, дахин үнэлгээний нэмэгдэл, эздийн өмчийн бусад хэсэг, өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	214,867.80	203,619.60	(11,248.20)
Авлага	2,438,742.80	1,293,850.90	(1,144,891.90)
Татвар ,НДШ-ийн авлага	157.30	-	(157.30)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,617.40	139,041.60	134,424.20
Бараа материал	512,248.40	538,314.40	26,066.00
Үндсэн хөрөнгө	18,740,698.30	18,118,991.10	(621,707.20)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>21,911,332.00</b>	<b>20,293,817.60</b>	<b>(1,617,514.40)</b>
Өр төлбөр	719,960.00	232,741.70	(487,218.30)
Татвар, НДШ-ийн өр	488,683.20	167,448.30	(321,234.90)
Богино хугацаат зээл	1,081,899.40	300,899.20	(781,000.20)
Урьдчилж орсон орлого	28,537.60	15,577.60	(12,960.00)
Урт хугацаат өр төлбөр	1,841,366.60	1,841,366.60	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	8,121,022.20	7,696,314.90	(424,707.30)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,924,821.60	15,459,856.70	12,535,035.10
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	12,535,035.10	512,609.70	(12,022,425.40)
Хуримтлагдсан ашиг	(5,829,993.70)	(5,932,997.10)	(103,003.40)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>21,911,332.00</b>	<b>20,293,817.60</b>	<b>(1,617,514.40)</b>

Авлага дансны үлдэгдэл буурсан нь авлага баталгаажуулалтыг бүрэн хийж, хуулийн байгууллагад хандах үйл ажиллагааг дорвитой хийснээр авлага буурч байна. Авлага дансны үлдэгдэлд 2011-2015 онуудад үүссэн, он удаан жил болсон 137,973.2 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байна. Үүнээс хуулийн байгууллагад хандахад үйл ажиллагаа явуулаагүй, эзэн холбогдогч нь тодорхойгүй, албан ёсны хаяг байхгүй, хариуцагч байгууллагууд нь дампуурсан, данс бүртгэлийн алдаатай зэрэг шалтгааны улмаас авлагыг барагдуулах боломжгүй, эрсдэлтэй 109,128.6 мянган төгрөгийн авлага байна. Мөн шүүхээр баталгаажуулан эзэн холбогдогчтой тохиролцсон, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар албадан гүйцэтгүүлэхээр болсон 28,844.6 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь бетон цутгалтын хэв /шугамын лоткийг худалдаж авах биш өөрсдөө цутгаж хийснээр зардлыг тодорхой хэмжээгээр бууруулна/ худалдан авснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй байгаа бараа материал байхгүй.

Автопаркын шинэчлэл хийгдсэн, цэвэр усан хангамжийг автоматжуулалт хийсэн, гэр хорооллыг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбосон нь үндсэн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ. Орон нутгийн төсөв, болон өөрийн хөрөнгөөр 512,609.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан харин хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө байхгүй байна.

363,355.8 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгийг БЗӨБЦТС ТӨХК-д үнэ төлбөргүй шилжүүлсэн, 84,277.3 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгийг акталсан байна.

Үндсэн хөрөнгийн данс	Анхны өртөг	Элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлсэн байгууллага
Барилга, байгууламж	231700,00	112731,1	117968,9	БЗӨБЦТС ТӨХК
Тоног төхөөрөмж	282732,9	37346,0	245386,9	БЗӨБЦТС ТӨХК
<b>Дүн</b>	<b>514432,9</b>	<b>150077,1</b>	<b>363355,8</b>	
Барилга, байгууламж	8186,5	7442,7	743,9	АИТХурлын 74, 81 дугаар тогтоол
Тоног төхөөрөмж	519469,6	436431,4	83038,2	АИТХурлын 74, 81 дугаар тогтоол
Тавилга эд хогшил	18227,1	17731,9	495,2	АИТХурлын 74, 81 дугаар тогтоол
Компьютер түүнтэй адилтгах хөрөнгө	3842,4	3842,4		АИТХурлын 74, 81 дугаар тогтоол
<b>Дүн</b>	<b>549725,6</b>	<b>465448,4</b>	<b>84277,3</b>	

Биет бус хөрөнгө 2019 онд 32,812,5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь дулааны зуухын нүүрсний конвейрын автоматжуулалтын программ хангамжийг орлогод бүртгэж авснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь банкны зээлийг 72,2 хувь, Шивээ овоо ХХК-ийн нүүрсний өр авлагыг 60 хувиар бууруулсан, НДШимтэлийн өрийг 100% барагдуулан, Мига эрин зуун ХХК-ийн нүүрсний өрийг барагдуулсантай холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөр нь 2007-2009 онуудад хийгдсэн Азийн хөгжлийн банкны хөнгөлөлтэй зээлээр хийгдсэн хөрөнгө оруулалтаас үүссэн 1,841,366.6 мянган төгрөгийн өр байна. Зээлийн хүүгийн зардлыг бүртгээгүй.

Өр төлбөр дансны үлдэгдэлд богино хугацаат банкны зээл 300,899.2 мянган төгрөг байгаа нь нийт өр төлбөрийн 11,7% хувийг эзэлж байна. Бусад өр төлбөр байхгүй.

Дүрмийн сан /Эздийн өмч/ дансны үлдэгдэл 15,459,856.7 мянган төгрөг болж 12,535,035.1 мянган төгрөгөөр өссөн нь гадны зээл, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг өмнөх тайлант онуудад эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэж байсан бөгөөд уг дүнгээр эздийн өмчийг нэмэгдүүлж, компаний дүрэмд өөрчлөлт оруулснаас шалтгаалжээ. Эздийн өмч нэмэгдсэнээр татварын эрсдэлгүй болж, банкнаас болон олон улсын байгууллагаас зээл авахад эерэг үзүүлэлт болно.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 423,852.8 мянган төгрөгийн бичилт нь актлагдсан хөрөнгийн дахин үнэлгээний хэрэгжилтийн бүртгэлтэй холбоотой байна.

## **2.9. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

2019 онд 6,713,106.0 мянган төгрөгийн орлогын, 7,075,415.7 мянган төгрөгийн зардлын төлөвлөгөөг ТУЗ-өөс баталсан бөгөөд тайлант онд үндсэн болон туслах үйл ажиллагааны борлуулалтын орлого 7,954,038.8 мянган төгрөг, хүүгийн орлого 2,236.9 мянган төгрөг, түрээсийн орлого 6,088.7 мянган төгрөг бусад орлого 20,316.6 мянган төгрөг буюу нийт 7,982,681.0 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна. Үйл ажиллагааны зардлыг авч үзвэл борлуулсан бүтээгдэхүүний өртөг 7,161,659.2 мянган төгрөг, борлуулалт маркетингийн зардал 153,263.3 мянган төгрөг, ерөнхий ба удирдлагын зардал 523,507.1 мянган төгрөг бусад зардал 83,938.9 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны алдагдал 572,743.5 мянган төгрөг буюу тайлант хугацааны нийт алдагдал 512,431.0 мянган төгрөг байна.

## **2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 14 горим сорил хэрэгжүүллээ. Аудитаар нийт 23,262.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, алдаа зөрчлийг арилгах 2 албан шаардлага өгч, 23,262.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгч байна.

Аудитаар илэрсэн 23,262.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

### **2.10.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. 2019 онд нэмэлт өөрчлөлт оруулсан компаний дүрэм, ТУЗ болон захирлын хооронд байгуулсан гэрээ нь доорхи холбогдох хуулийн заалтуудтай нийцэхгүй байна. Тухайлбал:
  - ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 30 тоот тогтоолоор компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж 2019 оны 5 дугаар сарын 21-ний өдөр улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байна. Уг дүрмийн 6.6.5 заалтын “хөрөнгө оруулалт хийх” хэсэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 заалт, 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.2.4 заалт, Компаний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1, 2.6 заалтуудтай нийцэхгүй байна.

- ТУЗ болон компаний захирлын хооронд байгуулсан 2019 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 01 тоот гэрээний 4.3 заалтын “шууд худалдан авалт хийх” хэсэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3 заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлтэй нийцэхгүй байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 заалт, 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.2.4 заалтууд, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйл, Компаний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1, 2.6 заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөх.

2. 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар 20 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 3 зөвлөмжийг биелүүлээгүй байна. Тухайлбал:
  - Нярвын орон тоо байхгүй салбаруудад нярвын ажлыг нягтлан бодогч хавсран гүйцэтгэхгүй байх.
  - Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг зааврын дагуу хөтлөх.
  - Мөнгөн урьдчилгаа /дараа тайлан/ олгох, тайлагнах, хяналт тавих, бүртгэл хөтлөх тусгайлсан журам баталж мөрдөх зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 заалт, 20 дугаар зүйлийн 20.2.4 заалт, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөх.

### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар компаний дүрэм, ТУЗ болон захирлын хооронд байгуулсан гэрээний заалтууд холбогдох хуульд нийцэж байгаа эсэх, шинээр худалдан авах үндсэн хөрөнгийн жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг аймгийн ИТХ-аар батлуулсан эсэхийг авч үзэх нь зүйтэй байна.

### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Чандмань илч ОНӨХХК нь шилэн дансны нэгдсэн [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 149 мэдээлэл байршуулахаас 147 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 20 зөвлөмж өгснөөс 2019 оны жилийн эцсийн байдлаар төлбөрийн акт, албан шаардлагыг бүрэн биелүүлж, зөвлөмжийн биелэлт 85 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Чандмань илч ОНӨХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Чандмань илч ОНӨХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

##### 3.1.1 Илрүүлэлт:

Компаний НБББББ-ийг шинэчлэн боловсруулж 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн А/18 тоот тушаалаар баталсан бөгөөд тус бодлогоор биет бус хөрөнгийн ашиглах хугацаанд өөрчлөлт орсон байна. Гэвч бодлогын өөрчлөлтийг санхүүгийн тайлан, тодруулгад тусгаагүй биет бус хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 23,262.3 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

Энэ нь үнэлгээ ба хуваарилалт үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4 заалт, НБББББ-ийг тус тус зөрчсөн байна.

##### 3.1.2 Эрсдэл:

Биет бус хөрөнгийн элэгдлийг буруу тооцоолсноос санхүүгийн тайлан, ашиг алдагдал буруу илэрхийлэгдэх.

##### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

НБББББ-т заасан ашиглах хугацаагаар хуримтлагдсан элэгдлийг тооцоолж бодлогын өөрчлөлтийг бүртгэлд тусгах.

##### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй.

3.2 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.2.1 Илрүүлэлт:

2019 онд шинээр авсан үндсэн хөрөнгийн жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг ИТХ-аар батлаагүй байхад үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3 дахь заалтыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Хууль журмын хэрэгжилтийг хангаагүй байх, хууль зөрчих.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3 дахь заалтыг мөрдөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй.

3.3 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

3.3.1 Илрүүлэлт:

ТУЗ-ийн 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 04 тоот тогтоолоор баталсан 2019 оны үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөгөөр 362,309.6 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн боловч 2019 онд 6,720,668.3 мянган төгрөгийн орлого, 7,577,715.4 мянган төгрөгийн зардал буюу төлөвлөсөн хэмжээнээс 494,737.5 мянган төгрөгийн алдагдал илүү хүлээсэн байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна ТУЗ-ийн 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 04 тоот тогтоолыг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Зардлыг төлөвлөсөн хэмжээнээс хэтрүүлсэн байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Алдагдлын шалтгааныг судлан арга хэмжээ авч ажиллах, батлагдсан төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, Бизнес төлөвлөгөөг татварын тайлантай биш санхүүгийн тайлантай уялдуулан батлуулах, ТУЗ болон захирлын хооронд байгуулсан гэрээнд төлөвлөгөөний биелэлтийн талаар захирлын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой тусгах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 48 тоот тогтоол, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 67 тоот тогтоол, компаний захирлын 2019 оны А/69 тоот

хөрөнгө шилжүүлэх тухай тушаалын дагуу 363,355.8 мянган төгрөгийн үлдэх өртөг бүхий хөрөнгүүдийг БЗӨБЦТС ТӨХК-д шилжүүлсэн, ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 74, 82 тоот тогтоолуудын дагуу 84,277.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталж үндсэн хөрөнгө хассаны гарз дансанд бүртгэснээр 447,633.1 мянган төгрөгийн алдагдал үүссэн. Мөн НБББББ-ийн дагуу 127,842.7 мянган төгрөгийн найдваргүй авлагын зардлыг бүртгэсэн нь алдагдал өсөхөд нөлөөлсөн. 2019 онд ААНОАТ-ын тайлангаар 144,251.8 мянган төгрөгийн ашигтай ажилласан тул ТУЗ болон захирлын хооронд байгуулсан гэрээ хангалттай сайн биелсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

#### 3.4.1 Илрүүлэлт:

Салбаруудын санхүүгийн тайланг нэгтгэсэн санхүүгийн тайлантай тулган шалгахад зөрүү гараагүй бөгөөд 2019 онд санхүүгийн тайланд залруулга хийгдсэн байна. Гэвч алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой заасан баримт байхгүй, зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулаагүй, алдаа гарсан үеийн тайланд тусгаж залруулаагүй тайлант үед тусгасан байна.

Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг зөрчсөн байна.

#### 3.4.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланд хийсэн тооцоолол, залруулга нь баримтаар нотлогдохгүй байх.

#### 3.4.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу залруулгыг хийж ажиллах.

#### 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй.

### 3.5 Балансын данстай холбоотой асуудал

#### 3.5.1 Илрүүлэлт:

Компаний захирлын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/128 тоот тушаалаар тооллогын комиссын бүрэлдэхүүнийг томилж, тооллого хийсэн боловч тооллогын тооцоо бодсон акт /НХМаягт БМ-7/-ыг хөтөлж, комиссоор баталгаажуулаагүй байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалыг зөрчсөн байна.

#### 3.5.2 Эрсдэл:

Бараа материалын тооцоо бодолт, түүний үр дүнг шийдвэрлээгүй байх, илүүдэл дутагдал гарсныг баталгаажуулаагүй байх.

### 3.5.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан заавар, маягтыг мөрдөх, эд хариуцагчийн тооцоо бодсон баримтыг холбогдох нягтлан бодогч 2 хувь нөхөн бичиж тооллогын комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах. Баримтын нэг хувь нягтлан бодогчид, үлдэх хувь эд хариуцагчид хадгалагдана.

### 3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй.

## 3.6 Балансын данстай холбоотой асуудал

### 3.6.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын хөдөлгөөнд холбогдох анхан шатны баримт болох НХМаягт ҮХ-1 маягтыг хөтөлсөн боловч батлагдсан заавар маягтын дагуу хөтлөөгүй байна. Өөрөөр хэлбэл худалдан авсан хөрөнгийг комисс хүлээж авдаггүй, хөрөнгийн ашиглалт, чанар, бүрэн бүтэн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөөгүй байна.

Энэ нь иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалыг зөрчсөн байна.

### 3.6.2 Эрсдэл:

Үндсэн хөрөнгийн чанар, бүрэн бүтэн байдалд тавих хяналт сулрах.

### 3.6.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан заавар, маягтыг мөрдөж ажиллах. ҮХ-1 маягтыг аж ахуйн нэгж, байгууллага үндсэн хөрөнгийг шинээр хүлээн авах буюу зохих шийдвэрээр шилжүүлэхэд байгууллагын дарга, захирлын тушаал болон холбогдох шийдвэрээр томилогдсон комисс хөрөнгийн нэр төрөл бүр дээр хүлээн авахад нэг хувь, шилжүүлэхэд 2 хувь нөхөж бичих. Үндсэн хөрөнгийг шинээр хүлээн авахад томилогдсон комисс дагалдан ирсэн баримт бичгийг үндэслэн ҮХ-1 маягтыг асуултын дагуу нөхөн бичиж, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирлаар батлуулан, дагалдах баримтыг хавсарган ажлын 3 хоногийн дотор нягтлан бодогчид ирүүлэх.

### 3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй.

## 3.7 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

### 3.7.1 Илрүүлэлт:

ААНОАТ-ын тайлан санхүүгийн тайлантай уялдаагүй, татварын тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийг татварын зорилгоор тооцоогүй, хуримтлагдсан элэгдлийг НБББББ-ийн дагуу санхүүгийн тайлан, тодруулгад тодруулаагүй байна.

Энэ нь эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 заалт, ААНОАТ-ын тухай хуулийн холбогдох заалт, Татварын ерөнхий газрын даргын 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А/73 тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

### 3.7.2 Эрсдэл:

Тайлан буруу буюу ашиг алдагдал буруу тооцоолох, тайлангийн уялдаа зөрүүтэй байх.

### 3.7.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг НБББББ-ийн дагуу тохируулах, татварын зорилгоор үндсэн хөрөнгийн тооцооллыг хийх, Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 заалт, Татварын ерөнхий газрын даргын 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А/73 тоот тушаалаар баталсан зааврыг мөрдөж ажиллах.

### 3.7.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

ТЕГ-ын даргын 2017 оны А/73 тоот тушаалаар баталсан зааврыг бүрэн ойлгоогүйгээс ААНОАТ-ын тайланг буруу тайлагнасан байна. Иймд татварын байгууллагад хүсэлт илгээж тайланг засварласан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг нотлох баримтын хамт Төрийн аудитын газарт 2020 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан**

---

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Байгууллагын нэр : "Чандмань илч" ОНӨХХК

/төгрөгөөр /

	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	214,867,805.64	203,619,648.62
1.1.2	Дансны авлага	2,437,311,556.00	1,292,594,526.90
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	157,291.00	-
1.1.4	Бусад авлага	1,431,243.33	1,256,461.97
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	512,248,355.42	538,314,400.64
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,617,450.00	139,041,576.16
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>3,170,633,701.39</b>	<b>2,174,826,614.29</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	16,258,762,012.13	15,615,532,152.20
1.2.2	Биет бус хөрөнгө	2,481,936,324.71	2,503,458,865.79
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>18,740,698,336.84</b>	<b>18,118,991,017.99</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>21,911,332,038.23</b>	<b>20,293,817,632.28</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	719,960,048.57	232,741,721.04
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	398,044,120.68	167,448,372.77
2.1.1.4	НДШ - ийн өглөг	90,639,102.09	

2.1.1.5	Богино хугацаат зээл	1,081,899,452.05	300,899,222.79
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	28,537,632.93	15,577,614.38
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,319,080,356.32</b>	<b>716,666,930.98</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	1,841,366,587.73	1,841,366,587.73
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,841,366,587.73</b>	<b>1,841,366,587.73</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>4,160,446,944.05</b>	<b>2,558,033,518.71</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	2,924,821,597.13	15,459,856,685.46
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	8,121,022,173.06	7,696,314,963.48
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	12,535,035,088.33	512,609,701.20
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(5,829,993,764.34)	(5,932,997,236.57)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг / алдагдал /	(255,511,798.98)	(526,856,240.87)
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг / алдагдал /	(5,574,481,965.36)	<b>(5,386,269,829.38)</b>
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>17,750,885,094.18</b>	<b>17,735,784,113.57</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>21,911,332,038.23</b>	<b>20,293,817,632.28</b>

**АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

Байгууллагын нэр : "Чандмань илч" ОНӨХХК

/төгрөгөөр /

	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>7,791,078,016.15</b>	<b>7,954,038,758.77</b>
2	Борлуулалтын өртөг	7,168,992,397.66	7,161,659,233.78
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>622,085,618.49</b>	<b>792,379,524.99</b>
4	Түрээсийн орлого		6,088,727.30
5	Хүүний орлого	19,318,113.39	2,236,893.04
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		20,316,579.86
9	Борлуулалт, маркетингийн зардал	140,727,315.75	153,263,338.82
10	Ерөнхий ба удирдлагын зардал	507,784,484.23	523,507,120.45
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	69,864,353.41	83,938,910.67
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(2,240,840.86)	2,579,914.33
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(166,904,753.32)	(447,633,110.54)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)	(9,063,006.14)	(127,690,273.34)
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>(255,181,021.83)</b>	<b>(512,431,114.30)</b>
19	Орлогын татварын зардал	330,777.15	14,425,126.57
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(255,511,798.98)</b>	<b>(526,856,240.87)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(255,511,798.98)</b>	<b>(526,856,240.87)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(255,511,798.98)</b>	<b>(526,856,240.87)</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

**АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

**Байгууллагын нэр : "Чандмань илч" ОНӨХХК**

/ мян.төгрөгөөр /

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	2019 оны 12-р сарын 31
1	<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,924,821,597.13</b>	<b>4,642,921,053.10</b>	<b>11,249,989,242.38</b>	<b>(5,557,340,556.90)</b>	<b>13,260,391,335.71</b>
2	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(17,141,408.46)	<b>(17,141,408.46)</b>
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,924,821,597.13</b>	<b>4,642,921,053.10</b>	<b>11,249,989,242.38</b>	<b>(5,574,481,965.36)</b>	<b>13,243,249,927.25</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(255,511,798.98)	<b>(255,511,798.98)</b>
5	Бусад дэлгэрэнгүй орлого			<b>1,285,045,845.95</b>		<b>1,285,045,845.95</b>
6	Өмчид гарсан өөрчлөлт					-
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		<b>3,478,101,119.96</b>			<b>3,478,101,119.96</b>
9	<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,924,821,597.13</b>	<b>8,121,022,173.06</b>	<b>12,535,035,088.33</b>	<b>(5,829,993,764.34)</b>	<b>17,750,885,094.18</b>
10	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				<b>423,852,768.64</b>	<b>423,852,768.64</b>
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,924,821,597.13</b>	<b>8,121,022,173.06</b>	<b>12,535,035,088.33</b>	<b>(5,406,140,995.70)</b>	<b>18,174,737,862.82</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-			(526,856,240.87)	<b>(526,856,240.87)</b>
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-
14	Өмчид гарсан өөрчлөлт	<b>12,535,035,088.33</b>		<b>(12,022,425,387.13)</b>		<b>512,609,701.20</b>
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний		<b>(424,707,209.58)</b>			<b>(424,707,209.58)</b>

	нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
1 7	2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	15,459,856,685. 46	7,696,314,963. 48	512,609,701.20	(5,932,997,236.5 7)	17,735,784,113. 57

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын нэр : "Чандмань илч" ОНӨХХК

/төгрөгөөр /

	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>7,575,155,584.87</b>	<b>10,370,127,020.40</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,986,543,336.28	9,625,293,335.59
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	136,259.00	
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	502,406.00	292,500.00
	Буцаан авсан албан татвар	142,477.00	
	Татаас, санхүүжилтийн орлого	525,964,300.00	593,300,000.00
	Бусад мөнгөн орлого	61,866,806.59	151,241,184.81
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>7,881,515,862.56</b>	<b>9,069,819,929.09</b>
	Ажиллагчдад төлсөн	1,678,319,604.23	1,909,335,901.25
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	469,724,452.77	605,978,506.67
	Бараа материал худалдан авахад төлсөн	3,099,877,281.32	3,535,195,537.07
	Ашиглалтын зардалд төлсөн	1,001,453,204.55	825,553,411.58
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	476,013,005.60	545,651,946.80
	Хүүний төлбөрт төлсөн	1,000.00	-
	Татварын байгууллагад төлсөн	496,174,666.93	1,036,656,569.82
	Даатгалын төлбөрт төлсөн	16,273,658.89	9,971,973.00
	Бусад мөнгөн зарлага	643,678,988.27	601,476,082.90
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(306,360,277.69)</b>	<b>1,300,307,091.31</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		-
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		-
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		

	Хүлээн авсан хүүний орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
	Бусад		-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>501,645,166.00</b>	<b>468,919,720.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	466,478,186.00	441,263,470.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	35,166,980.00	27,656,250.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(501,645,166.00)</b>	<b>(468,919,720.00)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,141,300,000.00</b>	<b>700,000,000.00</b>
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,141,300,000.00	700,000,000.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
	Валютын ханш		
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>262,007,720.18</b>	<b>1,542,635,528.33</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	262,007,720.18	1,542,635,528.33
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		-
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
	Валютын ханш		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>879,292,279.82</b>	<b>(842,635,528.33)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>71,286,836.13</b>	<b>(11,248,157.02)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>143,580,969.51</b>	<b>214,867,805.64</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>214,867,805.64</b>	<b>203,619,648.62</b>